



МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 11521

Бүтээлийн нэр

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН СИСТЕМ

Нийтийн хүртээл болсон огноо

2020 оны 02 сарын 10 өдөр

Бүтээлийн төрөл

Компьютерын програм

Зохиогч

МИША АМАРТОГОХ
САНЧИРДОРЖ МӨНГӨНЦЭЦЭГ

Эрх эзэмшигч

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

Монгол Улсын Оюуны Өмчийн Газрын Даргын 2022 оны 03 сарын 07-ны
өдрийн А/27 дугаар тушаалаар бүртгэж гэрчилгээ олгов.

ДАРГА

Г.ЭЛБЭГСАЙХАН

Улаанбаатар хот





ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН СИСТЕМИЙН ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН БҮТЭЭЛ АШИГЛАХ ОНЦГОЙ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 12 сарын 22 өдөр

№ 05

Улаанбаатар хот

Энэхүү “Бүтээл ашиглах онцгой эрх шилжүүлэх гэрээ” /цаашид “Гэрээ” гэх-/г Монгол улсын Зохиогчийн эрхийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон, Нэг талаас Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, 24A байр 307 тоотод байрлах 5915244 регистрийн дугаартай Дижитал медик ХХК /цаашид “Зохиогч” гэх-/ийг төлөөлж гүйцэтгэх захирал М.Амартоогох /рд:МТ85080118/, нөгөө талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны гудамж, 13б байр өөрийн байранд байрлах 9086331 регистрийн дугаартай Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид “Зохиогчийн эрх эзэмшигч” гэх-/ийг төлөөлж Эрүүл мэндийн мэдээллийн албаны дарга Б.Доржмягмар /рд:ИО87010611/, хамтад нь “Талууд” гэх/ нар харилцан тохиролцож, дараах нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Зохиогчийн эрхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийг үндэслэн хавсралтад дурдсан бүтээлийг Зохиогч болон Зохиогчийн эрх эзэмшигч нар хэлцэл хийн, харилцан зөвшилцэж эдэлбэл зохих эрх, үүргийг Зохиогчийн эрх эзэмшигчид бүрэн шилжүүлэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

1.2. Зохиогчийн эрх эзэмшигч нь бүтээлийг Монгол Улсын нэгдэн орсон Оюуны Өмчтэй холбогдох аливаа олон улсын гэрээнд хамарагдах бусад улс оронд өөрийн үйл ажиллагаандaa ашиглах, хуулбарлах, нийтлэх, нийтэд түгээх, үүсмэл болгон өөрчлөх, лицензээр ашиглаулах зэргээр хязгаарлагдахгүйгээр бүрэн ашиглах онцгой эрхтэй байна.

1.3. Зохиогчийн эрхийн тухай хуулийн хуулийн 36.1-т заасан гэрээг заавал бичгээр байгуулах мөн 36.3-т заасны дагуу Эрх шилжүүлэх гэрээнд тусгайлан заагаагүй бүтээл ашиглах бусад онцгой эрх нь зохиогчийн эрх эзэмшигчид хадгалагдана.

1.4. Зохиогч нь зохиогчийн эрх эзэмшигчид бүтээлийн эх хувийг өмчлөх эрхийг шилжүүлснээр зохиогчийн тус бүтээл дэх бүтээл ашиглах онцгой эрх зохиогчийн эрх эзэмшигчид бүрэн шилжсэнд тооцно.

1.5. Гэрээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагад танилцуулахаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд хувилж тараахгүй байх үүргийг Талууд хүлээнэ.

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Зохиогч эрх, үүрэг:

2.1.1. Зохиогч нь эзэмшигч буюу Зохиогчийн эрх эзэмшигчийг эдэлбэл зохих эрх үүргийг эдлэхэд аливаа хориг, саад тавихгүй байх үүрэгтэй.

2.1.2. Зохиогч нь бүтээлийн зохиогч, туурvigчийн эрхийг бусдад шилжүүлэх, өв залгамжуулах, төлбөр хураамж авах зэрэг аливаа хэлбэрээр ашиглахгүй байх үүрэгтэй.

2.2. Зохиогчийн эрх эзэмшигчийн эрх, үүрэг:

2.2.1. Зохиогчийн эрх эзэмшигч нь Бүтээлийг хуулийн хүрээнд эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

2.2.2. Бүтээлийг үүсмэл болгон өөрчлөх эрхийг эдэлнэ.

2.2.3. Энэхүү Гэрээг төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх эрхтэй.

ГУРАВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

3.1. Талууд энэхүү Гэрээгээр тохиролцсон үүргээ бүрэн биелүүлээгүйгээс нөгөө талд учирсан хохирлыг буруутай тал хариуцан барагдуулна.

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ТӨЛБӨР

4.1. Бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлсэнтэй холбоотойгоор Зохиогчийн эрх эзэмшигч нь аливаа төрлийн төлбөр, хураамж, хувь, ашиг шим, шан харамжийг Зохиогчид төлөхгүй болно.

ТАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

5.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргаантай асуудлыг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

5.2. Хэрэв талууд нь гэрээнээс үүдэлтэй гарсан маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсад мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1. Дараах хавсралтууд нь Гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болно. Үүнд:

6.1.1. Эрүүл мэндийн хөгжлийн төв, Дижитал медик ХХК-ны хамтарсан Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сангийн програм хангамжийн ажлыг гүйцэтгүүлэх, хөгжүүлэх Г202012161141 дугаар гэрээ

6.2. Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчилнэ,

6.3. Гэрээнд оролцогч талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээний аливаа заалтад нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ нь гагцхуу бичгээр үйлдэгдэж, бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурна. Ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь үндсэн гэрээний салшгүй хэсэг байна.

6.4. Гэрээг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хуулийн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗОХИОГЧИЙН ЭРХ ЭЗЭМШИГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн
Эрүүл мэндийн мэдээллийн албаны
дарга

Б.Доржмягмар

УХА0436 9066331

ЗОХИОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Дижитал медик” ХХК-ний гүйцэтгэх
захирал

УЛААНБАATAR ХОТ

M.Амартогох

“Дижитал медик” ХХК-ний програмист

С.Мөнгөнцэцэг

УХА2947 5915244

С.Мөнгөнцэцэг



МОНГОЛ УЛС
ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН
ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 11521

Бүтээлийн нэр

ХУНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН СИСТЕМ

Туурвисан огноо

2019 оны 12 сарын 31 өдөр

Бүтээлийн төрөл

Компьютерийн программ

Бүтээл өмчлөгч

“ДИЖИЛТАЛ МЕДИК” ХХК

Бүтээл туурвигч

САНЧИРДОРЖ МӨНГӨНЦЭЦЭГ, МИША АМАРТОГТОХ

Монгол Улсын Оюуны Өмчийн Газрын Даргын 2020 оны 04 сарын
03-ны өдрийн А/68 дугаар тушаалаар олгов.

ДАРГА

Ц.АЗБАЯР

1118267067
6324983
11172954

Улаанбаатар хот

